



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 2/615

Хэрлэн сум


Мэдээллийн ил тод байдлыг
хангахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 31 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Засгийн газрын бодлого шийдвэр, шинээр гарсан хууль тогтоомж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд олон нийтэд танилцуулах, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангахад 3,600,000 (гурван сая зургаан зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны... дугаар сарын...-ны
... дугаар захирамжийн хавсралт

ЗАРДАЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайлангийн сэтгүүл	3000	5300	15,900,000
	Эх бэлтгэл			500,000
	Нийт үнэ			16,400,00